

Томилох эрх бүхий албан тушаалтан нь:

1. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр салбарын хэмжээний бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд:
 - “Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлига гарч болох нөхцөлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд “ИРГЭН ТАНД” хуудсыг байгууллагын үйлчилгээнд нэвтрүүлж, үлдэх хуудсанд хүсэлтийг хүлээн авсан үйлчилгээний ажилтны нэр, хүлээн авсан огноо, цаг, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой www.ebarilga.ub.gov.mn, гар утасны аппликэйшн татаж авах линк, байгууллагын цахим хуудас www.uda.ub.gov.mn, Авлигатай тэмцэх газрын мэдээлэл өгөх линкүүдийн QR кодыг байршуулсан. Авлигатай тэмцэх газраас гаргасан “ИРГЭН ТАНД” хуудасны талаарх шторкийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллав.
 - Газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг төлөвлөгөөнд заасан хугацааны дагуу ханган ажиллаж байна.
 - “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарах асуудал”, “Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам”, “Зөвшөөрлийн тухай хуулийн танилцуулга”, “Засгийн газар дахь хяналтын тухай хууль”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль”, “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын талаар 6 удаагийн сургалт зохион байгуулсан.
 - Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудсанд 2 удаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар хийсэн ажлын мэдээллийг байршуулж, ил тод байдлыг хангаж ажилласан.



2. *Дэд хорооны үйл ажиллагаа, урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн, чадавх бэхжүүлсэн талаар:*
 - Ёс зүйн дэд хорооны гишүүдэд өмнөх журмын дагуу 2024 оны 04 дүгээр сарыг дуустал 20%-ийн нэмэгдэл цалин олгосон. Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/443 дугаар захирамжийн дагуу байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан.
 - Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, НЗДТГ-аас хамтран 2024 оны 03 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт төлөвлөгөөт сургалтад ёс зүйн дэд хорооны дарга Д.Уранбайгаль хамрагдаж, сертификат авсан. Сургалтаар байгууллагын ёс зүйн менежментийн дэд бүтцэд үнэлгээ хийж, хамрагдсан 42 байгууллагаас сонгосон 5 байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд Хот байгуулалт, хөгжлийн газар /хуучнаар/ 91.1 оноогоор тэргүүлсэн.
3. *Хариуцсан салбар, байгууллагад ёс зүйн зөрчил гарч байгаа болон үүсч болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийсэн, эрсдэлийг бууруулахаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:*
 - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/91 дүгээр захирамжийн дагуу ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, ажил сайжруулах зорилгоор газрын Хөдөлмөрийн дотоод журамд хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулан Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар батлав. Журмын төслийг нийт албан хаагчдад танилцуулж, 100 хувийн саналаар батлав.
 - Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан **55** удаагийн сургалтад (цахимаар 24, танхимын 31) давхардсан тоогоор **720** албан хаагч (100 хувь) хамрагдав.
 - Гадаад улсад зохион байгуулагдсан сургалт, семинар, хурал зөвлөгөөнд Газрын даргын тушаалаар 6 удаагийн сургалт, албан томилолтоор 15 албан хаагч (14 хувь) хамрагдав.

Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь:

1. *Хууль, тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт болон өгсөн зөвлөмж:*
 - Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан **55** удаагийн сургалтад (цахимаар 24, танхимын 31) давхардсан тоогоор **720** албан хаагч (100 хувь) хамрагдав.
 - Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн төрийн албаны туршилтын хугацаанд ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахиулан ажилласан талаар 5 албан хаагчийн талаарх дүгнэлтийг гаргаж ажилласан.
 - Шинээр томилогдсон 16 албан хаагчдад 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмуудыг танилцуулах сургалт зохион байгуулж, мэдээллүүдийг хүргэж, шинээр томилогдсон албан хаагчид цаашдын ажилдаа хууль, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах тухай маягт дээр гарын үсгээр баталгаажуулсан.



3. *Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэл:*
 - Албан хаагчтай холбоотой 10 гомдол, 3 талархал, 1 хүсэлтийг хүлээн авч, байгууллагын Ёс зүйн дэд хороо болон нийт албан хаагчдад танилцуулсан. Ирүүлсэн 10 гомдлоос 2 иргэний гомдлыг татуулж,
 - 1 иргэний гомдолд хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлж,
 - Албан хаагчийн буруутай 1 гомдолд иргэнээс уучлал гуйж гомдлыг барагдуулсан.
 - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдолд үүссэн нөхцөл байдлын талаар тайлбар өгч ажиллав.
 - Захиргаа, удирдлагын хэлтсээс /хуучнаар/ нэг албан хаагчийн ажлын цаг ашиглалттай холбоотой ирүүлсэн гомдлыг хүлээн авч, Ёс зүйн дэд хорооны II, III дугаар хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг гомдол гаргагчид танилцуулсан. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01-06/426 дугаартай албан бичгээр 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлийн мэдээллийг тайлагнаж хүргүүлсэн.
4. *Дэд хорооны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажлын тайлан:*
 - 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, 70% хэрэгжилттэй ажиллаж байна. Хавсралт №3-т үзүүлэв.
5. *Гомдол, мэдээллийг хянан шалгасан дүгнэлт:*
 - Захиргаа, санхүүгийн хэлтсээс /хуучнаар/ Тооцооны нягтлан бодогч С.Баасансүрэнгийн ажлын цаг ашиглалттай холбоотой ирүүлсэн гомдлыг хүлээн авч, Ёс зүйн дэд хорооны II дугаар хурлаар хэлэлцүүлж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6, болон 15 дугаар зүйлийн 15.1.2 дугаар заалтын дагуу гомдолд холбогдогчоос нэмэлт тайлбар, тодруулга авах, 2024 оны ажлын цагийн тооцоо, бүртгэлийг нягтлан дахин III дугаар хурлаар хэлэлцэж, гомдолд дурдсан асуудлыг нэгжийн хурлын протоколоор баталгаажуулах тул ёс зүйн зөрчил тогтоогдоогүй гэж дүгнэсэн. Гомдолд холбогдогч өөрийн хүсэлтээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.10, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтуудын дагуу гомдол гаргасан нэгжээсээ уучлалт гуйх санал гаргаж, ажлын цаг ашиглалт болон ёс зүйн хувьд анхаарч ажиллахаа илэрхийлсэн.
6. *Дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлын мэдээ:*
 - Байхгүй.

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт

Аймаг, хот: Улаанбаатар хот

Байгууллагын нэр: Хот байгуулалт, хотын стандартын газарт

№	Үзүүлэлт			Тоон мэдээлэл
1.	Хүлээн авсан гомдол, мэдээллийн нийт тоо:			9
	Үүнээс:	Гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр	Бичгээр	
			Цахим шуудангаар	
			Амаар	
			1111 төвийн харилцах утсаар	8
			Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ	
			Дотоодын хяналт шалгалтаар	1
		Гомдол, мэдээллийг зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсэн үндэслэл	Гэмт хэргийн шинжтэй	
			Сахилгын шинжтэй	
			Зөрчлийн шинжтэй	
			Бусад	1
2.	Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагчийн нийт тоо:			1
	Үүнээс:	Хүйс	Эр	
			Эм	1
		Албан тушаал	Төрийн улс төрийн	
			Төрийн захиргааны	
			Төрийн тусгай	
			Төрийн үйлчилгээний	1
			Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон	

			компанийн эрх бүхий албан тушаалтан	
			Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал	
			Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан	
			Авлигын эсрэг хуулийн 4.1.9-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн	
		Төрийн албан хаагчийн тухай хуульд заасан Албан тушаалын төрөл	Удирдах	
Гүйцэтгэх	1			
Туслах				
3.	Ёс зүйн зөрчилд холбогдуулан шалгасан гомдол, мэдээллийн нийт тоо:			1
	Ёс зүйн зөрчлийн ангилал	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1, 8.2-т заасан зөрчлийн ангиллаар		
4.	Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:			
5.	Шийдвэрлэсэн ёс зүйн зөрчлийн нийт тоо:			
	Үүнээс:	Ёс зүйн зөрчил гаргаагүй:		
		Ёс зүйн зөрчил гаргасан:		1
6.	Ёс зүйн хариуцлага ногдуулсан, хүлээсэн тоо:			1
	Үүнээс:	Томилох эрх бүхий албан тушаалтны	Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйхыг үүрэг болгох	

		шийдвэрээр ёс зүйн хариуцлага ногдуулсан	Олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох	
			Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах	
			Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах	
			Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах	
	Сайн дураар ёс зүйн хариуцлага хүлээсэн	Хамт олноос уучлалт гуйх	1	
		Гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйх		
		Олон нийтийн өмнө уучлалт гуйх		
		Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх		
7.	Харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороонд гаргасан гомдлын тоо:			-
Үүнээс:	Судлагдаж байгаа /шийдвэрлээгүй/ гомдол, мэдээлэл:			
	Дүгнэлтийг хэвээр үлдээсэн:			
	Дүгнэлтийг хүчингүй болгосон:			
8.	Шүүхэд гаргасан гомдлын тоо:			-
Үүнээс:	Шийдвэрийг хэвээр үлдээсэн:			
	Шийдвэрийг хүчингүй болгосон:			

Тайлан гаргасан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Д.Уранбайгалы/

Тайланг хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга

/ Б.Оюунтуяа /



ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт	Биелэлтийн хувь
1	2	3	4
1	Газрын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Ёс зүйн дэд хорооны 2024 оны I дүгээр хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.	100%
2	Газрын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулах	Газрын ёс зүйн дүрмийг Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-тай нийцүүлэн шинэчлэн боловсруулсан.	70%
3	Сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан 55 удаагийн сургалтад (цахимаар 24, танхимын 31) давхардсан тоогоор 720 албан хаагч (100 хувь) хамрагдав.	70%
4	Шинээр томилогдсон албан хаагчдад мэдээлэл өгөх	Шинээр томилогдсон 16 албан хаагчдад 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмуудыг танилцуулах сургалт зохион байгуулж, мэдээллүүдийг хүргэж, шинээр томилогдсон албан хаагчид цаашдын ажилдаа хууль, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах тухай маягт дээр гарын үсгээр баталгаажуулсан.	100%
5	Газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө-Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх	Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог хангаж, авлигын эсрэг НЭГДБЕ аяныг орон даяар зарласан. Уг аянаар дамжуулан хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэх, хүнд	100%

	үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдлийг бууруулж, иргэдийг авлигын эсрэг шүгэл үлээхэд түлхэц үзүүлэх зорилготой юм. Тус аяны хүрээнд Авлигатай тэмцэх газраас боловсруулан гаргасан авлигатай холбоотой хэвлэмэл хуудас, зурагт мэдээллүүдийг албан хаагчдад танилцуулан, ажлын байранд байршуулж ажилласан. Төлөвлөгөөний 9-д хийгдсэн судалгааны үр дүнд төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, харилцаа, хандлага, хувцаслалт, ажлын байрны эмх, цэгц, цаг ашиглалт зэрэг мэдээллүүдээр ЗӨВЛӨМЖ боловсруулж, танилцуулан, ажлын өрөөнүүдэд байршуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	
6	Газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө- Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн санал, зөвлөмжийг байгууллагын үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж байна.	70%
7	Газрын мэдээллийн самбар болон хэлтэс өрөөнүүдэд эерэг үгс байршуулах, Талархалын аян зохион байгуулах;	Нийт алба хаагчдыг хамруулсан Талархалын аян зохион байгуулж захианы хайрцаг бэлтгэж, захиаг хүргэсэн.	100%
8	Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг цаасан болон цахимаар хүлээн авах, шийдвэрлэх	Албан хаагчтай холбоотой 10 гомдол, 3 талархал, 1 хүсэлтийг хүлээн авч, байгууллагын Ёс зүйн дэд хороо болон нийт албан хаагчдад танилцуулсан. Ирүүлсэн 10 гомдлоос 2 иргэний гомдлыг татуулж, - 1 иргэний гомдолд хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлж, - Албан хаагчийн буруутай 1 гомдолд иргэнээс уучлал гуйж гомдлыг барагдуулсан. - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдолд үүссэн нөхцөл байдлын талаар тайлбар өгч ажиллав.	100%
9	Албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага, байгууллагын соёлын талаар судалгаа боловсруулан,	Ёс зүйн дэд хорооны 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн II дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу байгууллагын нийт албан хаагчдын авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэж байгаа эсэхэд төлөвлөгөөт	100%

	судалгаа авч үр дүнг даргын зөвлөлд танилцуулах	бус үзлэг, асуумжаар албан хаагчдын хувцаслалт, харилцаа, хандлага, цаг ашиглалт, ажлын байрны эмх цэгц зэрэг ерөнхий агуулгаар судалгаа авсан. Уг судалгаанд байгууллагын 75 албан хаагчдыг хамруулахад харилцаа 93.8%, албан хувцаслалтын байдал 89.1%, ажлын байран дээрх цаг ашиглалт 96.2%-тай нэгдсэн дүнтэй гарсан.	
10	Үйл төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнах, цахим хуудсанд нээлттэй байршуулах	Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудсанд 2 удаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар хийсэн ажлын мэдээллийг байршуулж, ил тод байдлыг хангаж ажилласан. ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллав.	100%
11	Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах	Ёс зүйн дэд хорооны 7 гишүүн, бусад 8 алба хаагч нийт 15 албан хаагчид Удирдлагын академийн Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад амжилттай хамрагдаж, сертификат авсан.	100%

ХЯНАСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.ОЮУНТУЯА

Д.УРАНБАЙГАЛЬ